



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН



Ерөнхий дүгнэлт

Аймаг болон зарим сумдын сонгуулийн хороод нь батлагдсан зардлыг холбогдох байгууллагын шийдвэргүйгээр зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулж, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгасан байна.

Сүхбаатар сум

2017 он

Тайланг бэлтгэсэн:

Сэлэнгэ аймаг дахь
Төрийн Аудитын
газар

Тэргүүлэх аудитор:
Ч.Энхтуяа

Аудитын менежер:
Б.Батмөнх

Ахлах аудитор:
С.Баасансүрэн

Аудитор:
Б.Эрдэнэзул
Э.Эрдэнэзул

Аудитын
тайлан, дүгнэлттэй
холбоотой
асуудлаар нэмж
тодруулах, асууж
лавлах зүйл гарвал
70362442, 70363047,
70363040 дугаарын
утас, 70363040
дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ: Сэлэнгэ
аймгийн
ЗДТГ-ын байрны
өргөтгөлд

2017 оны 7-8 дугаар
сар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй
Үндсэн мэдээлэл

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан эсэх.

1.1 Төсвөөс олгох хөрөнгийг сонгуулийн хороодод холбогдох журмын дагуу хуваарилсан эсэх.

1.2 Батлагдсан төсвийг зориулалтын дагуу захиран зарцуулсан эсэх.

2. Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх.

2.1 Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөлт, гүйцэтгэлийн тайланг журмын дагуу тайлагнасан эсэх.

2.2 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль, журмын дагуу гүйцэтгэсэн эсэх.

Илрүүлсэн зөрчил**Дүгнэлт****Зөвлөмж**

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ҮАГ	Үндэсний Аудитын газар
СЕХ	Сонгуулийн Ерөнхий хороо
ОӨУБЕГ	Оюуны өмч, улсын бүртгэлийн Ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
СХ	Сонгуулийн хороо
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

1. Аудит хийх үндэслэл

Аудитыг Монгол улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2017 оны “Аудитын сэдэв батлах тухай” 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

2. Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтыг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв. Уг зорилтын хүрээнд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг сонгуулийн хороодод холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан эсэх.
2. Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьсан эсэх.

3. Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороодод улсын төсвөөс олгосон хөрөнгийн санхүүжилт, зарцуулалт, тайлагнал, хяналт шалгалтын баримтуудыг хамруулав.

4. Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, Нийцлийн аудитын түр журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөний дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан мэдээг холбогдох байгууллагуудаас гаргуулж шинжлэн судалж, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг арга зүй, горимыг хэрэгжүүлэв. Аудитын дүгнэлтэд дэмжлэг болох нотолгоо, холбогдох шинжилгээ, судалгааг тайланд хавсаргав.

5. Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Сонгуулийн тухай хууль,
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль,
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль,
- СЕХ-ны 2016 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”,
- СЕХ-ноос батлан гаргасан бусад журам, заавар, зөвлөмж,
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт.

Хоёр. Үндсэн мэдээлэл

УИХ-аас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шинэчлэн баталсан Сонгуулийн тухай хуулийн 16.1, 16.3, 16.6 дахь заалтуудын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийг 6 дугаар сарын 26-ны өдөр явуулахаар товлон зарласан бөгөөд сонгуулийн зардлыг 15.7 тэрбум төгрөгөөр баталсан байна.

Сэлэнгэ аймгийн СХ-нд 53,444.4 мянган төгрөгийн, сумдын СХ-нд 68,158.6 мянган төгрөгийн, санал авах байранд 146,825.6 мянган төгрөгийн зэрэг нийт 268,428.6 мянган төгрөгийн санхүүжилтийг хуваарилсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн анхан шатны санал хураалтаар нэр дэвшигчдийн хэн нь ч олонхийн санал аваагүй тул хоёр дахь шатны санал хураалтыг 2017 оны 7 дугаар сарын 7-нд явуулахаар тогтоожээ.

СЕХ нь хоёр дахь шатны санал хураалт явуулах зардалд аймгийн СХ-нд 78,442.0 мянган төгрөгийн, сумдын СХ-нд 9,315.0 мянган төгрөгийн, санал хураах байранд 7,920.0 мянган төгрөгийн зэрэг нийт 95,677.0 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмж хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хороо нь Сонгуулийн тухай хуулийн 31.4¹ дэх заалтын дагуу 2017 оны 04-р сарын 12-ны өдрийн 10 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн СХ-г 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан байна.

Аймгийн СХ нь Сонгуулийн тухай хуулийн 33.4² дэх заалтын дагуу 2017 оны 04-р сарын 21-ний өдрийн 2 дугаар тогтоолоор сумдын Сонгуулийн хороог 5-7

¹ Сонгуулийн төв байгууллага аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр, санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

² Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сум, дүүргийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэйгээр санал авах өдрөөс 65-аас доошгүй хоногийн өмнө байгуулна.

хүний бүрэлдэхүүнтэй, сумдын Сонгуулийн хороо нь Сонгуулийн тухай хуулийн 35.2³, 35.3⁴ дах заалтын дагуу 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр хэсгийн хороог тус тус байгуулсан байна.

ОӨУБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст сонгогчдын нэрсийн жагсаалт үйлдэх, бүртгэх, цахим мэдээллийн санд байрлуулах, санал авах техник хэрэгслийг татаж авах, сумдын СХ-нд хүргүүлэх, итгэмжлэгдсэн албан хаагчдын сургалт зохион байгуулах болон унаа, хоол, томилолтын зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 60,944.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газарт санал авах байр болон саналын хуудас хүлээн авах, хүлээлгэн өгөх үеийн хамгаалалтад ажиллах цагдаагийн албан хаагчдын хоол, шатахуун, холбооны зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 10,808.0 мянган төгрөгийг санхүүжилтийг олгосон байна.

³ Санал авах байр нь ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч гэсэн орон тоотой, таваас долоон хүний бүрэлдэхүүнтэй байна.

⁴ Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал авах байрыг санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө байгуулж, ахлах зохион байгуулагчийг томилно.

Гурав. Аудитын дүн

Бүлэг 1

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу хуваарилж, зарцуулсан эсэх.

Аймаг болон зарим сумдын сонгуулийн хороо нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зардлын гүйлгээ хийсэн байна.

1.1 СЕХ-нь сонгуулийн зарим зардлыг орон нутгийн бодит үнэ, жишиг тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хуваарилсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.1⁵ дэх заалтын дагуу СЕХ-нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийн зардлын төлөвлөлтийг хийж, УИХ-аар батлуулсан бөгөөд холбогдох тооцооллын дагуу аймаг, сумын Сонгуулийн хороо, санал авах байрны зардлыг эдийн засгийн ангиллаар нь лимит тогтоон, баталж ирүүлсэн байна.

Сонгуулийн эхний шатны санал хураалтын зардлын санхүүжилтийг СЕХ-ны 2017 оны 04-р сарын 26-ны өдрийн 113 дугаар албан бичгээр 32,512.0 мянган төгрөгийн, 2017 оны 05-р сарын 30-ны өдрийн 172 дугаар албан бичгээр 60,005.0 мянган төгрөгийн, 2017 оны 06-р сарын 13-ны өдрийн 199 дугаар албан бичгээр 27,780.0 мянган төгрөгийн, 2017 оны 06-р сарын 21-ний өдрийн 199 дугаар албан бичгээр 148,131.6 мянган төгрөгийн зэрэг нийт 268,428.6 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд хуваарилж, бүрэн шилжүүлсэн байна. Эхний шатны санал хураалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

⁵ Сонгууль зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг хүн амын тоог сонгуулийн нутаг дэвсгэртэй харьцуулан гаргасан сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухай бүр батална.

Хүснэгт 1 /мянган төгрөг/

Сонгуулийн зардлын нэгтгэл тайлан								
Д/д	Тайлбар	Нийт төсөв	Аймгийн сонгуулийн хороо		Сумын салбар хороо		Санал авах байр	
			төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
	Нийт зардлын дүн	268,428.6	53,444.4	40,589.7	68,158.6	67,933.6	146,825.6	146,825.6
1	Тогтоол, протокол,бусад маягт хэвлүүлэх	250.0	250.0	250.0				
2	Гэрчилгээ олгох сургалтын зардал	3,776.0	3,776.0	3,613.0				
3	СХ-ны гишүүдийн сургалтын зардал	5,266.0	2,888.0	2,874.3	2,378.0	2,378.0		
4	МТДаамлын сургалтын зардал	6,870.0	6,870.0	5,957.6				
5	Бичиг хэргийн зардал	14,640.0	800.0	800.0	3,400.0	3,400.0	10,440.0	10,440.0
6	Шуудан холбоо	13,790.0	800.0	799.9	2,550.0	2,550.0	10,440.0	10,440.0
7	Тээвэр шатахууны зардал	26,200.0	2,000.0	2,000.0	6,800.0	6,800.0	17,400.0	17,400.0
8	Санал авах байр бэлтгэх зардал	11,600.0					11,600.0	11,600.0
9	Сурталчилгааны зардал	8,000.0	2,200.0	2,200.0	5,800.0	5,800.0		
10	Сурталчилгааны материал хүргүүлэх зардал	2,125.0			2,125.0	2,125.0		
11	Саналын хуудас устгах зардал	700.0	700.0	700.0				
12	Саналын хуудас , Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	14,392.0	14,392.0	12,740.0		-		
13	Томилолтын зардал /, Сонгуулийн дүнг СЕХ-нд хүргэх, сумаас аймгийн СХ-нд хүргэх, санхүүгийн тайланг СЕХ-нд хүргэх зардлын тайлан/	4,252.0	4,252.0	1,009.5				
14	Мэдээ дамжуулах зардал	3,000.0	2,625.0	620.0	375.0	150.0		
15	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	2,436.0	2,191.0		245.0	245.0		
16	Болзошгүй зардал	3,000.0	3,000.0	325.0				
17	Сонгуулийн байгууллагын ажилтны урамшуулал, хоолны зардал	126,961.6	5,060.4	5,060.4	24,955.6	24,955.6	96,945.6	96,945.6
18	МТБ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	21,170.0	1,640.0	1,640.0	19,530.0	19,530.0		

Хүснэгтээс харахад СЕХ-нь сонгогчийн болон хэсгийн тоо, газар нутгийн хэмжээ, аймаг, сумын Сонгуулийн хороо, санал авах байранд ажиллах болон мэдээллийн технологийн багийн гишүүдийн тоог харгалзан зардлын хуваарийг хийсэн хэдий ч зарим зардлуудыг үндэслэл муутай төлөвлөж, хуваарилсан байна.Тухайлбал:

- Аймгийн Сонгуулийн хорооны сонгуулийн дүн болон зардлын тайланг СЕХ-нд хүргэх томилолтын зардал тодорхой, бодитоор тооцох боломжтой байхад уг зардлыг өндөр дүнгээр тооцоолж 3,242.5 мянган төгрөгийг илүү хуваарилсан,
- Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх, мэдээ дамжуулах болон болзошгүй зардлыг аймаг, сумын СХ-дод ямар нэг жишиг тооцоололгүйгээр, өндөр дүнгээр төлөвлөж 7,096.0 мянган төгрөгийг илүү хуваарилсан байна.

Сонгуулийн 2 дахь шатны санал хураалтын зардлын санхүүжилтийг СЕХ-ны 2017 оны 06-р сарын 03-ны өдрийн 260 дугаар албан бичгээр 38,077.0 мянган

төгрөгийн, 2017 оны 07-р сарын 18-ны өдрийн 295 дугаар албан бичгээр 57,600.0 мянган төгрөгийн зэрэг нийт 95,677.0 мянган төгрөгийг аймгийн Сонгуулийн хороонд хуваарилж, бүрэн олгосон байна. 2 дахь шатны санал хураалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2 /мянган төгрөг/

Сонгуулийн зардлын нэгтгэл тайлан								
Д/д	Зардлын төрөл	Нийт төсөв	Аймгийн сонгуулийн хороо		Сумын салбар хороо		Санал авах байр	
			төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл
	Нийт зардлын дүн	95,677.0	78,442.0	74,226.5	9,315.0	9,315.0	7,920.0	7,920.0
1	Бичиг хэргийн зардал	1,310.0	100.0	100.0	1,210.0	1,210.0		
2	Шуудан холбоо	1,600.0	100.0	100.0	1,500.0	1,500.0		
3	Унааны зардал	3,575.0	250.0	250.0	3,325.0	3,325.0		
4	Саналын хуудас хүргэх	4,862.0	4,862.0	14,338.5				
5	Санал тоолох төхөөрөмж хүргэх, буцаан татах зардал	9,814.0	9,814.0					
6	Мэдээ дамжуулах зардал	3,000.0	3,000.0	1,558.0				
7	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх зардал	2,436.0	2,436.0					
8	Сонгуулийн байгууллагын ажилтны хоолны зардал	11,480.0	280.0	280.0	3,280.0	3,280.0	7,920.0	7,920.0
9	Урамшууллын зардал	57,600.0	57,600.0	57,600.0				

Дээрхээс харахад СЕХ-нь 2 дахь шатны санал хураалтад эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх, мэдээ дамжуулах зардлыг ямар нэг жишиг тооцоололгүйгээр, өндөр дүнгээр төлөвлөж аймгийн Сонгуулийн хороонд 3,878.0 мянган төгрөгийг илүү хуваарилсан байна.

СЕХ-нь 2 удаагийн санал хураалтын зарим зардлыг орон нутгийн бодит үнэ, жишиг тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хуваарилсан байна.

1.2 Аймаг болон зарим сумдын Сонгуулийн хороо нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар зардлын гүйцлээ хийсэн байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулахад СЕХ-оос аймгийн Сонгуулийн хороонд эхний шатны санал хураалтад 268,428.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос гүйцэтгэлээр 255,348.8 мянган төгрөгийг, 2 дахь шатны санал хураалтад 95,677.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосноос гүйцэтгэлээр 91,461.5 мянган төгрөгийг зарцуулсан байна. Сонгуулийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3 /мянган төгрөг/

Д/д	Зардлын нэр	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Үлдэг дэл	
		Эхний санал хураалт	2 дахь санал хураалт	Эхний санал хураалт	2 дахь санал хураалт	Эхний санал хураалт	2 дахь санал хураалт
1	Саналын хуудас устгах	700.0		700.0			
2	Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх	250.0		250.0			

3	Сургалт	15912.0		14822.9		1089.1	
4	Бичиг хэрэг	14640.0	1310.0	14640.0	1310.0		
5	Шуудан холбоо	13790.0	1600.0	13789.9	1600.0	0.1	
6	Унаа	26200.0	3575.0	26200.0	3575.0		
7	Хууль тогтоомж сурталчлах	8000.0		8000.0			
8	Санал авах байр бэлтгэх	11600.0		11600.0			
9	Саналын хуудсыг УБ-аас авах, сумдад хүргэх, ИСР машиныг авах, өгөх	14392.0	14676.0	12740.0	14338.5	1652.0	337.5
10	МТБ-ийн мэдээ дамжуулах	3000.0	3000.0	770.0	1558.0	2230.0	1442.0
11	Томилолт	4252.0		1009.5		3242.5	
12	Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх	2436.0	2436.0	245.0		2191.0	2436.0
13	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоол	126961.6	57600.0	126961.6	57600.0		
14	МТБ-ийн урамшуулал, хоол	21170.0	11480.0	21170.0	11480.0		
15	Болзошгүй зардал	3000.0		325.0		2675.0	
16	Сурталчилгааны материал хүргүүлэх	2125.0		2125.0			
	НИЙТ ДҮН	268428.6	95677.0	255348.9	91461.5	13079.7	4215.5

Аймгийн СХ-нь эхний шатны санал хураалтын санхүүжилтээс 13,079.7 мянган төгрөгийн, 2 дахь санал хураалтын санхүүжилтээс 4,215.5 мянган төгрөгийн зэрэг нийт 17,295.2 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг СЕХ-ны 100900022001 болон 100900022401 тоот дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Аудитаар аймаг болон сумдын СХ-ны зардлын гүйцэтгэлийг анхан шатны баримттай нь тулган баталгаажуулахад анхан шатны баримтгүй ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан нийт 63,873.6 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

✚ Аймгийн СХ-нь томилолтоор ажилласныг нотлох баримтгүйгээр 3 удаагийн маршрутаар 300.0 мянган төгрөгийн шатахууныг зарлагдсан, сумдын СХ-ны гишүүдийн сургалтад ирсэн, буцсан унааны зардалд анхан шатны баримтгүйгээр 35.0 мянган төгрөгийг олгосон, сургалтын зардлаас 40.0 мянган төгрөгийн цэвэр ус худалдан авсныг нярвын тайланд орлогоор бүртгээгүй,

- ✚ Аймгийн СХ-нь 2 дахь шатны санал хураалтын өдөр Сүхбаатар сумын зарим иргэдийг Орхон голын урдаас зөөж гаргах, буцааж хүргэх моторт завины шатахууныг нормоор бус рейсээр тооцож 325.0 мянган төгрөгийг олгосон,
- ✚ Аймгийн СХ-нь 2 дахь шатны санал хураалтад ажилласан аймаг, сумдын СХ-ны гишүүд, санал авах байрны болон мэдээллийн технологийн багийн гишүүдийн урамшуулал 57,600.0 мянган төгрөгийг банкны түр дансанд шилжүүлсэн боловч нэрсийн жагсаалтыг банкны гүйлгээ хийсэн теллерийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй,
- ✚ Цагааннуур сумын СХ-нь хувь хүний дансанд 110.0 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд шилжүүлж, тамга тэмдэггүй нэхэмжлэх, зарлагын баримт хавсаргасан,
- ✚ Зүүнбүрэн сумын СХ, санал авах байранд ажилласан гишүүд, мэдээллийн технологийн даамлуудын хоол, урамшууллын мөнгийг банкны түр дансанд шилжүүлсэн боловч нэрсийн жагсаалт үйлдэж, хүлээн авсан хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулалгүй 4,585.6 мянган төгрөгийг олгосон,
- ✚ Сант сумын СХ-нь дахин санал хураалтын хоолны мөнгө 280.0 мянган төгрөгийг банкны түр дансанд шилжүүлсэн боловч нэрсийн жагсаалт үйлдэж, хүлээн авсан хүмүүсийн гарын үсгээр баталгаажуулалгүй олгосон,
- ✚ Орхон сумын СХ-ны дарга, гишүүн, ахлах, зохион байгуулагч нарт нийт 570.0 мянган төгрөгийн шуудан холбооны зардал олгосон ч эргэж тооцоо хийгээгүй, гүйцэтгэлийг нотлох баримтаар баталгаажуулаагүй,
- ✚ Хушаат сумын СХ-нь 28.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, шуудан холбооны зардлыг бэлэн авч зарцуулсан боловч кассын тайлан гаргаагүй, зарлагын баримт бүрдүүлээгүй байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.4 дэх “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Зүүнбүрэн сумын СХ-нь дахин санал хураалтын батлагдсан бичиг хэрэг, шуудан холбооны зардал 110.0 мянган төгрөгийг унааны зардалд гүйлгэн зарцуулах тухай хүсэлтийг аймгийн Сонгуулийн хороонд албан бичгээр тавьсан боловч албан ёсоор хариу өгөөгүй байхад /аймгийн СХ албан ёсоор зөвшөөрөл олгоогүй амаар өгсөн гэж тайлбарлалаа./ гүйлгэн зарцуулсан байна.

Орхон сумын СХ-нь дээд шатны Сонгуулийн хорооноос зөвшөөрөл авалгүйгээр санал авах байр бэлтгэх зардлаас 110.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, сурталчилгааны материал хүргэх зардлаас 40.0 мянган төгрөгийг эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх зардалд тус тус гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь СЕХ-ны 2016 оны 03-р сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 3.2⁶ дахь заалтыг зөрчсөн байна.

⁶ Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлын эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ.

Аймгийн СХ-нь 2017 оны 05-р сарын 16-ны өдрийн 04 тоот албан бичгээр сумдын сонгуулийн хороодод төсвийн зарцуулалтын талаар зөвлөмж хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйгээс унаагы зардлыг батлагдсан маршрутгүйгээр зарцуулсан, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоочийн үнэмлэхийг хавсаргаагүй зэрэг дараах 2,410.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

- ✚ Шаамар сумын СХ, санал авах байрын унааны зардалд батлагдсан 1360.0 мянган төгрөгийг маршрутгүйгээр зарцуулсан,
- ✚ Сант сумын СХ, санал авах байрнуудын унааны зардалд батлагдсан 540.0 мянган төгрөгийг зарцуулахдаа ажиллах газрын маршрут батлуулж хавсаргаагүй, сонгуулийн ажлаар явсан автомашины тээврийн хэрэгслийн гэрчилгээ, жолоочийн үнэмлэх хавсаргаагүй,
- ✚ Ерөө сумын СХ-нь сурталчилгааны материал хүргэх зардалд батлагдсан 110.0 мянган төгрөгийг зарцуулахдаа шатахууны тайланд ажиллах газрын маршрут батлуулж хавсаргаагүй,
- ✚ Баянгол сумын СХ-нь шатахууны зардалд батлагдсан 400.0 мянган төгрөгийг зарцуулахдаа шатахууны тайланд ажиллах газрын маршрут батлуулж хавсаргаагүй,
- ✚ Алтанбулаг, Орхон, Хүдэр сумдын СХ-д нь шатахууны тайланд сонгуулийн ажлаар явсан авто машины гэрчилгээ, жолоочийн үнэмлэх зэргийг хавсаргаагүй байна.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгуулийн зардлыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулж, анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.

ОӨУБЕГ-аас аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн нэмэлт санхүүжилтийн 100130012420 тоот дансаар дамжуулан эхний шатны санал хураалтын зардалд 42,276.5 мянган төгрөгийн, 2 дахь шатны санал хураалтын зардалд 18,658.9 мянган төгрөгийн зэрэг нийт 60,944.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. 2 удаагийн санал хураалтын зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл, үлдэгдлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4 /мянган төгрөг/

Д/д	Зардал	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Зөрүү	
		Эхний санал хураалт	2 дахь санал хураалт	Эхний санал хураалт	2 дахь санал хураалт	Эхний санал хураалт	2 дахь санал хураалт
1	Бичиг хэрэг болон шуудан, шатахууны зардал	10000.0	6050.0	9794.8	6054.4	205.2	-4.4
2	Томилолт, унааны зардал	8177.0	2150.0	8378.0	2135.5	-201.0	14.5
3	Итгэмжлэгдсэн ажилтны цалин, хоолны зардал	20379.6	10450.0	20370.1	10469.0	9.5	-19.0
4	УБ-аас тоног төхөөрөмжүүд авч ирэх, буцаан хүргэж өгөх зардал	3737.7		3742.5		-4.8	
	НИЙТ ДҮН	42276.5	18650.0	42285.4	18658.9	8.9	-8.9

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь дээд шатны төсвийн захирагчийн шийдвэргүйгээр зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна.Үүнд:

- Эхний шатны санал хураалтын бичиг хэрэг болон шуудан, шатахууны зардлаас томилолт, унааны зардалд 201.0 мянган төгрөгийг, итгэмжлэгдсэн ажилтны цалин, хоолны зардлаас тоног төхөөрөмжийн тээврийн зардалд 4.8 мянган төгрөгийг,
- 2 дахь шатны санал хураалтын томилолт, унааны зардал болон эхний шатны санал хураалтын санхүүжилтийн үлдэгдэл 23.4 мянган төгрөгөөс итгэмжлэгдсэн ажилтны цалинд 19.0 мянган төгрөгийг, бичиг хэргийн зардалд 4.4 мянган төгрөгийг тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Аудитаар аймгийн УБХ-ийн сонгуулийн зардлын гүйцэтгэлийг тулган баталгаажуулахад анхан шатны баримтгүй дараах 6,151.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан байна. Үүнд:

- ✚ Итгэмжлэгдсэн ажилтнуудын сургалтын зардлаас хоолны төлбөрт 1,993.0 мянган төгрөгийг зарлагын баримтгүйгээр, нэхэмжлэх үндэслэн Гэбиргэ ХХК-д шилжүүлсэн,
- ✚ 2017 оны 02-р сарын 10-ны өдрийн зарлагын баримтыг үндэслэн сургалтын зардлаас хоолны төлбөрт 100.0 мянган төгрөгийг Гүнж-Аялгуу ХХК-д шилжүүлсэн,
- ✚ Монгол-Шуудан ТӨХК-д шуудан, холбооны зардалд 3 удаа нийт 2,862.5 мянган төгрөгийг баталгаажсан шуудангийн төлбөрийн баримтгүйгээр, зөвхөн нэхэмжлэх үндэслэн шилжүүлсэн байна.
- ✚ 2 дахь шатны санал хураалт 2017 оны 07-р сарын 07-ны өдөр дууссан байхад 07-р сарын 28-ны өдрийн зарлагын баримт, нэхэмжлэхээр бичгийн цаасны үнэнд 901.0 мянган төгрөгийг Загастай-Үрс ХХК-д, бичиг хэргийн материалын үнэнд 295.4 мянган төгрөгийг Оюу-номун ХХК-д тус тус шилжүүлсэн байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20.1.4 дэх “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аймгийн Цагдаагийн газар нь сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

ЦЕГ-аас аймгийн Цагдаагийн газрын нэмэлт санхүүжилтийн 100130012401 тоот дансаар дамжуулан санал авах байр, сонгуулийн тоног төхөөрөмж болон саналын хуудас хүлээж авах, хүлээлгэн өгөх үеийн хамгаалалтад ажиллах цагдаагийн алба хаагчдын хоол, шатахуун, холбооны зардалд 2 удаагийн санал хураалтад нийт 10,808.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 5 /мянган төгрөг/

Д/д	Зардал	Төлөвлөгөө		Гүйцэтгэл		Үлдэгдэл	
		Эхний санал	2 дахь санал	Эхний санал	2 дахь санал	Эхний санал	2 дахь санал

		хураалт	хураалт	хураалт	хураалт	хураалт	хураалт
1	Холбоо	488.0	720.0	488.0	720.0		
2	Шатахуун	1200.0	1200.0	1200.0	1200.0		
3	Хоол		7200.0		7200.0		
	НИЙТ ДҮН	1688.0	9120.0	1688.0	9120.0		

Аймгийн Цагдаагийн газар нь ЦЕГ-аас олгосон санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Бүлэг 2

Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх.

Сонгуулийн зардлын гүйцэтгэлд аймаг болон сумын СХ-оос зохих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

2.1 Сонгуулийн зардлын бүртгэлийг зохих хууль, журмын дагуу хөтөлж, тайлагнасан байна.

СХХ-ны 2016 оны 03-р сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 4.3-т “ Сум, дүүргийн сонгуулийн хороо болон салбар комиссын сонгуулийн зардлын тайлан дараах хэсгээс бүрдэнэ: 4.3.1.сонгуулийн зардлын тайлан өгөх тухай албан бичиг, 4.3.2. тайлангийн товч танилцуулга, тодруулга, 4.3.3. сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлан, 4.3.4. санхүүгийн анхан шатны баримтууд /хүлээлгэн өгсөн акт/ ” гэж заасны дагуу сумдын СХ-д сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг бэлтгэж ирүүлэх учиртай. Гэтэл Зүүнбүрэн, Түшиг сумдын СХ-нь сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайлангийн товч танилцуулга, тодруулгыг ирүүлээгүй байгаа нь дээрх заалтыг зөрчихөд хүргэсэн байна.

Аймгийн СХ-нь Ерөө, Зүүнбүрэн, Сант, Сайхан, Орхонтуул, Түшиг, Цагааннуур сумдын СХ-ны зардлын гүйцэтгэлийн тайлан, санхүүгийн анхан шатны баримтыг акт үйлдэн хүлээж аваагүй байгаа нь СХХ-ны 2016 оны 03-р сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 4.6 дахь “Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сум, дүүргийн сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авч, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны санхүүгийн анхан

шатны баримтын хамт архивын нэгж болгон аймаг, нийслэлийн ИТХ-ын архивт албан ёсоор хүлээлгэн өгнө” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Аймаг болон сумдын СХ-д нь сонгуулийн зардлын бүртгэлийг холбогдох хууль, журмын дагуу хөтөлж, гүйцэтгэлийг аймгийн нэгдсэн тайланд зардлын зүйл тус бүрээр ангилан тайлагнасан бол Орхон сумын СХ урамшуулал, унаа хоолны зардлуудыг нэгтгэн тайлагнасан байлаа.

2.2 Сумдын сонгуулийн хорооноос хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Сонгуулийн тухай хуулийн 34.1-д “Сум, дүүргийн сонгуулийн хороо нь харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ: 34.1.6. улсын болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасан байдаг.

СЕХ-ны 2016 оны 03-р сарын 02-ны өдрийн 04 дугаар тогтоолоор батлагдсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах журам”-ын 3.1⁷-д заасны дагуу сумдын СХ-ны дарга 1 дүгээр гарын үсгийг, СХ-ны нарийн бичгийн дарга буюу томилогдсон нягтлан бодогч 2 дугаар гарын үсгийг зурж, зардлыг хуваарилж, ажил гүйлгээ гарах тухай бүрт анхан шатны баримт материал, хэрэгцээ шаардлагыг үндэслэн баталж, зохих ёсны хяналт тавьж ажилласан байна. Гэвч сонгуулийн зардлыг зориулалтын дагуу захиран зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан талаар тайлан мэдээ, илтгэх хуудас зэрэг холбогдох баримт материалыг үйлдээгүй байна.

Аймгийн СХ-ны зүгээс сумдын Сонгуулийн хороодын үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийсэн боловч хөрөнгө санхүүжилтийн зарцуулалтад шалгалт хийгээгүй байна.

Сумдын СХ-ны худалдан авсан бараа материалын үлдэгдлийг тухайн сумын ИТХ-д акт үйлдэн хүлээлгэж өгөхийг аймгийн СХ-оос зөвлөсөн байхад Цагааннуур сум 251.5 мянган төгрөгийн, Хүдэр сум 89.0 мянган төгрөгийн, Түшиг сум 82.5 мянган төгрөгийн, Алтанбулаг сум 45.0 мянган төгрөгийн зэрэг нийт 468.0 мянган төгрөгийн бичиг хэрэг, хангамжийн материалыг ИТХ-д хүлээлгэж өгөөгүй байна. Үүнийг дараах хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6 /мянган төгрөг/

Д/д	Сумын нэр	Бараа материалын нэр	Тоо ширхэг	Үнэ	
				Нэгж	Нийт
1	Хүдэр	Схем зураг	1	20.0	20.0
		Схем зураг	1	30.0	30.0
		Уртасгагч залгуур	1	25.0	25.0

⁷ Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо болон төв комисс, салбар комиссын дарга нь тухайн сонгуулийн хорооны зардлын дансны 1 дүгээр гарын үсгийг, томилогдсон нягтлан бодогч нь 2 дугаар гарын үсгийг зурж, энэ журмын 2.2, 2.3 дахь хэсэгт заасан хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулна.

		Үзэгний сав	1	14.0	14.0
2	Алтанбулаг	Лац	3	15.0	45.0
3	Цагааннуур	Үдээсний машин	3	5.0	15.0
		Томруулдаг шил	3	8.0	24.0
		Цоож	2	6.25	12.5
		Гэрийн бүрээс /плёнк/	20 м	3.5	70.0
		Шалны хулдаас	20 м	6.5	130.0
4	Түшиг	Уртасгагч	2	18.0	36.0
		Самбарын суурь	3	8.0	24.0
		Хайч	2	3.5	7.0
		Флаш	1	15.5	15.5
Нийт дүн					468.0

Иймээс дээрх бичиг хэрэг, хангамжийн материалыг тухайн сумын ИТХ-д акт үйлдэн хүлээлгэх өгөх шаардлагатай байна.

Дөрөв. Илрүүлсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн нийцлийн аудитаар дараах зөрчлүүдэд албан шаардлага бичигдлээ. Үүнд:

1. Аймгийн Сонгуулийн хороо-нд:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 63,873.6 мянган төгрөгийн ажил, гүйлгээг бүртгэлд тусгасан,
- Дээд шатны Сонгуулийн хорооны шийдвэргүйгээр 260.8 мянган төгрөгийг зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан,
- 2,410.0 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтын дэмжих анхан шатны баримт, материалыг бүрдүүлээгүй,
- 468.0 мянган төгрөгийн үнэ бүхий бичиг хэрэг, хангамжийн материалыг сумдын ИТХ-д хүлээлгэн өгөөгүй зэрэг нийт 67,012.4 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага бичигдлээ.

2. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс-т:

- Дээд шатны байгууллагын шийдвэргүйгээр 229.2 мянган төгрөгийг зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 6,151.9 мянган төгрөгийн ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан зэрэг нийт 6,381.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага бичигдлээ.

Тав. Дүгнэлт

- Сонгуулийн зарим зардлыг орон нутгийн бодит үнэ, жишиг тооцоо судалгаанд үндэслэлгүйгээр хуваарилсан байна.

- Аймаг болон зарим сумдын Сонгуулийн хороо нь хүчин төгөлдөр бус анхан шатны баримтыг үндэслэн зардлын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгасан байна.
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгуулийн зардлыг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр зардлын ангилал хооронд гүйлгэн зарцуулсан байна.
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл тайланд тусгасан байна.
- Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газар нь сонгуулийн зардлыг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Сонгуулийн зардлын бүртгэлийг зохих хууль, журмын дагуу хөтөлж, тайлагнасан байна.
- Сонгуулийн зардлын гүйцэтгэлд аймаг болон сумын СХ-оос зохих дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Зургаа. Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Сонгуулийн хорооны дарга Э.Оюунболд-д:

- Сумдын Сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу хянаж, хүлээн авах.
- Зардлын хуваарилалт, зарцуулалтад хяналт тавьсан талаарх тайлбарыг сумдын СХ -доор нөхөн гаргуулж, зардлын гүйцэтгэлийн тайлангийн тодруулгад хавсаргах.
- Сумдын СХ-дын зардлын гүйцэтгэлд хавсаргах анхан шатны баримтыг тодорхой зааж, заавар зөвлөмжөөр хангаж ажиллах.
- Сумдын СХ-ны зардлыг ангилал хооронд гүйлгэн зарцуулах шийдвэрийг зохих журмын дагуу гаргаж хүргүүлж байх.

Сумдын сонгуулийн хорооны дарга нарт:

- Батлагдсан зардлыг зориулалтын дагуу зарцуулан, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах.
- Сонгуулийн зардлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу аймгийн Сонгуулийн хороонд хүлээлгэн өгч байх.
- Сонгуулийн зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа аймгийн Сонгуулийн хорооны шийдвэр гаргуулах.
- Сонгуулийн зардлын санхүүжилтээр авсан бараа, материалын үлдэгдлийг сумын ИТХ-д акт үйлдэн хүлээлгэн өгч, бүртгэлд тусгуулах.

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Б.Саранчимэг-т:

- Сонгуулийн зардлыг ангилал хооронд гүйлгэн зарцуулахдаа эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулах.
- Анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангасны үндсэн дээр ажил, гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгаж байх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

Б.БАТМӨНХ

С.БААСАНСҮРЭН

Б.ЭРДЭНЭЗУЛ

Э.ЭРДЭНЭЗУЛ

ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛ:



СЭЛЭНГЭ АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

213200 Сүхбаатар сум, Сэлэнгэ аймаг
Утас/Факс: 7036-3966

2017.08.02 № 50
танай _____-ны № _____-т

АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тайлангийн төсөлтэй танилцсан тухай

Аймаг, сумын Сонгуулийн хороодоос Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуулийг зохион байгуулсан санхүүгийн зардлын гүйцэтгэлд хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд дурьдсан алдаа дутагдлыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд цаашид дахин гаргахгүй байх талаар анхаарч дотоод хяналтаа сайжруулан ажиллах болно.

ДАРГА



Э.ОЮУНБОЛД